

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН НӨГДҮҮГЭЭР ОРЛОГЧ  
Ж.БАТБАЯСГАЛАН



НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА

1118265139 9115064

Ж.ТОГТОХБАЯР

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ-1 -ИЙН ХҮРЭЭНД ТЗА-НЫ БУУДЛУУДЫН ХООРОНД 2  
ЭГНЭЭ ШУЛУУН ЗАМЫГ НААДАМЧДЫН ЗАМЫН ТУСГААРЛАХ ЗУРВАС  
ДЭЭР ШИНЭЭР БАРИХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
ДААЛГАВАР

2019 оны 02 сарын 18. өдөр

Дугаар 34 -19/078

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах  
үндэслэл

1.1. Монгол улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.224-р заалт “Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ”.

1.2. Улсын Их Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганаар хэлэлцэн баталсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай” Монгол Улсын хууль;

1.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ын 4 дүгээр зорилтын 2 дугаар үе шат (2021-2025);

1.4. “Монгол Улсын Засгийн газрын 2016 - 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.224 дэх заалт;

1.5. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.15 дахь заалт;

1.6. “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.7 дахь заалт;

1.7. Улсын Их хурлаар 2015 оны 05-р сард соёрхон батлагдсан “Нийслэлийн

нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Засгийн газар нь Азийн хөгжлийн банкнаа үйл ажиллагаагаа 2017 оны 05-р сараас эхлүүлэн хэрэгжүүлж байна. Техник эдийн засгийн судалгааг 2012 онд боловсруулсан ба Улаанбаатар хот дахь сүүлийн 5-н жилийн хугацаанд гарсан өөрчлөлтүүдийг тусгахын тулд 2016 онд дахин шинэчилсэн.

1.8. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын ... өдрийн А/... дүгээр захирамж

1.9. НХТETГ-ЫН 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн МЗХ2019/04-01 тоот Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар

- |  |  |
|--|--|
| 2. Байршил   | УБ, ХУД, 4, 8-р хороо, Наадамчдын гудамж зам   |
| 3. Хөрөнгө оруулалтын эх Нийслэлийн 2019 оны төсөв Үүсвэр              |  |
| 4. Замын техникийн ангилал, хүчин чадал                                | Гол гудамж зам - 1, 6.6 (буудал хоорондох 5.0) км  |
| 5. Замын эхлэл, төгсгөл  | Наадамчдын болон Сонсголонгийн гудамж замуудын уулзвар аюулгүй тойргоос Яармагийн гүүрийн урд талын эхлэл орчимд тусгаарлах зурvasын бүрэн өргөнтэй хэсгийн төгсгөл хүртэлх зам хамаарна.            |
| 6. Замын хучилтын хийц   | Тооцоогоор   |
| 7. Зураг төсөл зохиох үе шат, 1 үе шаттай, 2019 оны 2-р улирал хугацаа |  |
| 8. Төлөвлөлтийн норм   | <ul style="list-style-type: none"><li>• “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016,</li><li>• “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04</li></ul>                              |
| 9. Захиалагч байгууллага   | Нийслэлийн Авто замын хөгжлийн газар   |
| 10. Зураг төслийн иж бүрдэл  | <ul style="list-style-type: none"><li>• Инженер-геодезийн хайгуул судалгаа, байр зүйн зураглал</li><li>• Инженер-геологийн хайгуул судалгаа</li><li>• Буудал хоорондох авто замын ажлын иж</li></ul> |

- бүрэн зураг төсөл
- ИШС-ний холбогдох зураг төслүүд
- Бүх зураг төслийн иж бүрэн төсөв
- Зам барилгын техникийн шаардлага
- Зураг төслийн ажлын магадлалын ерөнхий дүгнэлт
- Зам барилгын ажлын тендерийн баримт бичиг

**Жич:**

1. Зураг төслийн иж бүрдэл нь эдгээр заалтуудаар хязгаарлагдахгүй бөгөөд шаардлагын дагуу нэмэгдэж болно.
2. Иж бүрэн зураг төсөл гэж тухайн байгууламжийн ажлын зураг төсөл болон түүнийг дагалдах инженерийн шугам сүлжээний бүх зураг төслийг ойлгоно.

#### 11. Онцгой нөхцөл

Авто замын зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Авто замын төсөллөх" ЗЗБНБД 22.004.2016, "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад холбогдох норм дүрэм, стандартуудыг үндэслэн зураг төслийг боловсруулах.

Наадамчдын авто замын тусгаарлах зурvas дээр барих Тусгай замын автобусны зориулалтын замыг 2 жижиг гүүрийн өргөсөлтийн хамт тус замын одоо байгаа түвшинтэй уялдуулан төлөвлөж зураг төслийг боловсруулах.

Хучилтын бүтээцийг тооцоот их багтаамжийн автобусны тэнхлэгийн ачаалал, зам – цаг уурын бүс, байгаль цаг уурын хүчин зүйлсийн үйлчлэл, газрын гадаргуун геологийн тогтоц, усдулааны горим гэх мэтчилэн бусад факторуудыг нарийвчлан тооцож төсөллөх.

Авто замын гадаргуугийн ус зайлцуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх.

Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх

Замын зурваст орсон хөндөгдөж буй аливаа шугам сүлжээг эзэмшигч байгууллагатай зөвшилцөж, шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөл гаргуулж, ажлын зураг төсөл боловсруулж батлуулсан байх.

Тусгай замын хөдөлгөөн зохион байгуулалтыг хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган улмаар зам, тээврийн ухаалаг

системийн шаардлагад нийцүүлж төсөллөх.

Геодезийн байнгын цэг тэмдэгтийг БД 11-104-06 -д заасан дагуу 2 км тутам байгуулж, хүлээлгэн өгөх. Магадлалд оруулж баталгаажуулах.

Орчин үеийн дэвшилтэд арга технологийг тусгах.

Зураг төслийг дараах масштабаар боловсруулна. Үүнд:

- |                     |                              |
|---------------------|------------------------------|
| • Дэвсгэр зураг     | 1:500                        |
| • Дагуу огтлол      | хэвтээ 1:1000<br>босоо 1:100 |
| • Хөндлөн огтлол    | 1:100                        |
| • Уулзвар огтлолцол | 1:100                        |
| • Хучилтын бүтээц   | 1:20                         |
| • Хэсэглэл          | 1:10                         |

Байр зүйн болон өндрийн хэмжилтийн UTM системд хийх. Авто замын үндсэн элементүүдийг (авто зам, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг, тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.

Зураг төслийг НАЗХГ, НГА, НХТETГ, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар, ТЦА, ЗХУТ болон Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй зөвшилцөнө.

Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3-н хэмжээст зураг, төслийн танилцуулга, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг зэрэг холбогдох баримт бичгүүдийг Азийн хөгжлийн банкны шаардлагад нийцүүлэн англи, монгол хэл дээр боловсруулах бөгөөд эх хувь 1 ширхэг, хуулбар хувь 3 ширхэг өнгөтөөр хэвлэн ирүүлнэ. Мөн цахим хэлбэрээр зураг төслийг pdf болон dwg өргөтгөлөөр ирүүлнэ.


#### Хянасан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
орлогч дарга



Б.ИНДРА

“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх  
хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл -1”-ийн  
зохицуулагч



А.ХҮРЭЛБАТ

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга



Р.БАТЦОЛМОН

**Боловсруулсан:**

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн Авто  
замын мэргэжилтэн

А.ОЮУНЧИМЭГ

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн Гүүрийн  
төлөвлөлтийн мэргэжилтэн



М.ИЧИНХОРЛОО

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн Усны  
барилга байгууламжийн мэргэжилтэн



Б.ЕРТИС

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн  
Авто замын инженер



Б.АМАРАА


Төсөл хэрэгжүүлэх нэгжийн  
Тээврийн инженер



Ж.ДАВААСҮРЭН

## НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

- Байршил: ХУД, 4, 8-р хороо
  - Газрын зориулалт: Авто зам



## Хянасан:

“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тесэл -1”-ийн зохицуулагч НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

А.Хүрэлбат

Р.Батцолмон

Боловсруулсан:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Авто замын инженер

Б.Амараа

НАЗХГ-ЫН Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

А.Оюунчимэг